

НАЙДАНГИЙН ДАНГААСҮРЭН (1925-2006)

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Найдангийн Дангаасүрэн хүнд өвчний учир 2006 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нас нөгчив.

Найдангийн Дангаасүрэн 1925 онд төрсөн. Дорноговь аймгийн Сайхандулаан сумын харьяат. Арван настайдаа Сайншанд хотын холбоонд цахилгааны нэвтрүүлэгчээр ажил үйлсийнхээ гарааг эхэлж, 1943-1946 онд МХЗЭ-ийн Төв хорооны хэлтэсийн эрхлэгч, хоёрдугаар нарийн бичгийн дарга, 1946-1952, 1956-1959 онд нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байв. 1915 онд Лондонд Дэлхийн ардчилсан залуучуудын холбоо үйл ажлаа эхэлсэн үеэс, уул холбоо болон Олон улсын оюутны холбооны үйл ажиллагаанд 1959 он хүртэл идэвхтэй оролцжээ.

БНМАУ-ын Бага хурлын гишүүн, Ардын Их Хурлын депутат МАХН-ын Төв Хорооны гишүүнээр удаа дараа сонгогдож байсан. Монголын Энх тайваны хороо, НҮБ-ыг дэмжих Монголын Хорооны орлогч даргын сонгууль хүлээж байв. 1955-1956 онд Хөвсгөл аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1959-1963 онд БНХАУ, БНАСАУ-д БНМАУ-аас суугаа элчин сайдын яамны зөвлөх, нэгдүгээр нарийн бичгийн дарга, Аж үйлдвэрийн комбинатын намын хорооны дарга, МҮЭ-ийн Төв зөвлөлийн гадаад харилцааны хэлтсийн дарга, сүүлийн дөч шахам жил ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Дорно дахины судлалын хүрээлэн, Зүүн хойт Ази судлал болон Олон улс судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, секторын эрхлэгчээр ажиллаж, судалгааны ажлыг тасралтгүй хийж байв.

Түүхч эдийн засагч Н.Дангаасүрэн нь улс төрийн хоёр дээд сургууль, Английн Лийдс, Кембрижийн их сургуулиудад олон улсын эдийн засаг, англи хэлний сургалт дүүргэж аспирантур, докторантурт суралцаж төгссөн байна. 1968 онд “Хөдөөгийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт” сэдвээр дэд доктор, 1978 онд “Гурав дахь ертөнц: Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалжээ.

Талийгаачийн ажилсаг, хүнлэг энэрэнгүй, нөхөрсөг тусч, ноён нуруутай, ухаалаг зан чанар нь бидний сэтгэл, зүрхэнд үүрд дурсагдах болно. Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлье.

Шинжлэх Ухааны Академи
Монголын Залуучуудын Холбоо
Монголын Үйлдвэрчний Холбоо
Монголын Ахмадын Холбоо
Олон Улс Судлалын Хүрээлэн
Дорноговь Аймгийн Нутгийн Зөвлөл